



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.02.02 № 06

Засгийн газрын 2025 оны 225 дугаар
тогтоолын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 382 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтоол батлагдсанаар боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад олгодог нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тооцохдоо Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолоор эрх шилжүүлж, 225 дугаар тогтоолд салбарын асуудал эрхэлсэн сайд нарын нэмэгдүүлэн тогтоосон цалингаас биш 2024 оны 238 дугаар тогтоолоор тогтоосон цалингийн доод хэмжээ, сүлжээнээс тооцон олгохоор болсон нь боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын гомдол, бухимдлыг зүй ёсоор төрүүлж, төрд итгэх итгэлийг бууруулж, цалингийн нэмэгдэл бодитойгоор мэдрэгдэхүйц бус нөхцөлийг бүрдүүлж байна.

Засгийн газрын дээрх шийдвэрүүдтэй холбоотойгоор боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид болон багш нарын үйлдвэрчний эвлэлийн зүгээс ирсэн санал гомдлуудад үндэслэн, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлан боловсруулахад шаардлагатай мэдээлэл авах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1.Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 225 дугаар тогтоол батлагдсанаар боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу олгогддог төрийн алба хаасан хугацааны, докторын зэрэг, профессор цолны, ур чадварын, мэргэшлийн зэргийн, орон нутгийн, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөлийн, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөлийн зэрэг нэмэгдлүүдийг тус тусын салбарын сайдын баталсан цалингийн хэмжээнээс биш Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн доод хэмжээ, сүлжээнээс тооцож олгохоор зохицуулсан. Хэрвээ Засгийн газраас 2025 оны 224 дүгээр тогтоолоо цуцалж, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ, сүлжээг салбарын сайд нарын тогтоосон хэмжээгээр тогтооход (Засгийн газрын тогтоол гаргахад) дээрх нэмэгдэл тус бүр, салбар тус бүрийн төсөвт хэдэн төгрөгний нэмэлт эх үүсвэр хэрэгтэй тухай тооцооллыг хүснэгтээр;

2.Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдыг тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжийг хэрхэн олгох харилцааг Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5,


2026000016

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6.3 дахь заалтуудаар тус тус зохицуулдаг. Үүний хүрээнд Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.3-т “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохдоо Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтална.” гэж заасан. Иймд Засгийн газраас боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ, сүлжээг харгалзах салбарын сайд нарын хүргэсэн түвшинд нэмэгдүүлэн тогтоосон тохиолдолд энэхүү нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоход салбар тус бүрийн төсөвт хэдэн төгрөгний нэмэлт эх үүсвэр хэрэгтэй тухай мэдээллийг хүснэгтээр;

3.Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т “сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.” гэж тус тус заажээ. Энэхүү тэтгэмжийг Засгийн газрын тогтоолоор баталсан цалингийн хэмжээнээс тооцон олгодог зохицуулалтыг Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын 3.2-т “Тэтгэмжийн хэмжээг Засгийн газраас тогтоосон албан тушаалын үндсэн цалингийн хэмжээгээр тооцно.”, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” А/531, 136 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэг, аймаг дахь төрийн болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн болон эмнэлгийн бусад мэргэжилтэнд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын 3.1-т “Мөнгөн тэтгэмжийн хэмжээг тооцохдоо Засгийн газрын тогтоолоор хамгийн сүүлд баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг баримтална.” гэж тус тус заасан байх тул боловсрол, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг салбарын сайд нарын тогтоосон түвшинд хүргэн, Засгийн газраас тогтоосноор энэхүү мөнгөн тэтгэмжийг олгоход боловсрол, эрүүл мэндийн салбарын төсөвт хэдэн төгрөгний нэмэлт эх үүсвэр хэрэгтэй тухай мэдээллийг тус тус хүснэгтээр ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

2026007016